



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 44 (569)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай*
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны арваннэгдүгээр сарын 28

№44 (569)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

718.	Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай	1186
719.	Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1186
720.	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1186

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

721.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай	Дугаар 31	1187
722.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 37	1188
723.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 38	1189
724.	Хууль, тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 39	1189

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

725.	Чимэдбазарын Дамдиншаравт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай	Дугаар 340	1190
726.	Цэдэндамбын Готовт Монгол Улсын гавъяат хуульч цол хүртээх тухай	Дугаар 341	1191
727.	Жамсрангийн Гэндэндарамд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 342	1191
728.	Дагвын Цахилгаанд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 343	1191
729.	Голимэнсээгийн Шилагардид Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 344	1191
730.	Шадравын Түдэвт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 345	1192
731.	Лувсансүрэнгийн Дамдинсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 346	1192
732.	Чулуундоржийн Янжмаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 347	1192



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИД БАТАЛГАА ГАРГАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Баталгаа

2.1. Банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс гаргах баталгаа нь мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий, Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид хамаарна.

2.2. Энэ хуулийн 2.1-д заасан баталгаа нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.3. Энэ хуулийн 2.2-т заасан баталгааны хугацаанд арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид учирсан хохирлыг төр бүрэн хариуцна.

3 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

3.1. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "7 дугаар сарын 1-ний өдрийг" гэснийг "11 дүгээр сарын 01-ний өдрийг" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг

батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "500 ам долларыг" гэснийг "850 ам долларыг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /А.Батсүх/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**
Монгол Улсын Их Хурлын 2008 оны
31 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2009 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрийн мөнгөний бодлого нь инфляцийг дунд хугацаанд тогтвортой, нам түвшинд хүргэж бууруулах замаар иргэдийн амьжиргааны түвшинг хамгаалах, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих, санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Санхүүгийн зах зээлийн бүтэц, дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Монголбанк инфляцийг бууруулахад чиглэсэн шийдвэрээ бие даасан, мөнгөний болон сангийн бодлогын харилцан уялдааг хангасан хэлбэрээр хэрэгжүүлнэ. Энэхүү бодлого нь төрийн бодлогын уламжлалыг хадгалсан, зах зээлийн өөрчлөлтийг тухай бүр тусгасан, дунд хугацааны зорилготой нийцсэн байдлаар хэрэгжинэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд

1.1.Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барьж, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.Мөнгөний бодлогын үр ашгийг нэмэгдүүлж, нээлттэй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ мөнгө, сангийн бодлогын харилцан уялдааг инфляцийг бууруулах, иргэдийн амьжиргааны түвшинг хамгаалах, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ.

1.3.Төгрөгийн ханш нь валютын захын эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр бодитой, чөлөөтэй тогтож байх зарчмыг баримтална.

1.4.Төлбөрийн тэнцэл гаргах, гадаад валютын урсгалын талаархи мэдээллийн хамрах хүрээ, хүртээмж, нээлттэй байдлыг сайжруулах, үр ашигтай ажиллах дэд бүтцийг бүрдүүлэх замаар дотоодын валютын захын үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.5.Гадаад валютын улсын нөөцийг түүний найдвартай байдал, төлбөр түргэн гүйцэтгэх

чадварыг хангасны үндсэн дээр үр өгөөжийг нь нэмэгдүүлэх зарчмаар удирдаж, нөөцийг импортын 17.7-гоос доошгүй долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байлгана.

1.6.Экспортын алт, зэс, импортын нефть зэрэг гол нэрийн бараа, түүхий эдийн үнийг ирээдүйн хандлагыг тодорхойлж, урьдчилсан таамаглал үийс хиад авч үзэх бий болгох замаар санхүүгийн үүсмэл хэрэгслүүдээр үнийн эрсдлийн зохицуулалт хийдэг болно.

1.7.Монголбанкинд тушаагдах алтны хэмжээ нь төлбөрийн тэнцэл, төсвийн орлого, валютын нөөцийн хэмжээнд нөлөөлж байгааг харгалзан тухайн жилд олборлосон алтыг Монголбанкинд бүрэн тушаадаг болгох арга хэмжээг хууль, эрх зүйн хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд

2.1.Банкны салбарын тогтвортой байдлыг хамгаалсан бодлого явуулна.

2.2.Банкны байгууллагын үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааг дэмжин, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд оновчтой нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг цогц хэлбэрээр үзүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон дэд бүтцийн орчныг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

2.3.Банкны харилцагч, хадгаламж эзэмшигч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, банкны байгууллагын үйлчилгээний шударга, ил тод, ойлгомжтой байдлыг сайжруулах, банкны ажилтны ёс зүйн зарчмуудыг мөрдөн ажиллуулах чиглэлд Монголбанкны үйл ажиллагааг өргөжүүлнэ.



2.4. Олон Улсын Төлбөр Тооцооны Банкны дэргэдэх Базелийн Санхүүгийн Тогтвортой байдлын Хорооноос гаргасан банкны хяналт, шалгалтын үндсэн зарчмуудыг бүрэн хэрэгжүүлснээр монголын банк, санхүүгийн байгууллагууд олон улсын зах зээлд хүрч ажиллах, хямд, урт хугацаатай хөрөнгө татан төвлөрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрсдэлийг үнэлж, хязгаарлах ажлыг хэрэгжүүлнэ.

2.5. Эрсдэлд суурилсан зохистой харьцааны үзүүлэлт ба санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх арга хэрэгслийг хослуулан хэрэглэх, түүнийг боловсронгуй болгох замаар санхүүгийн зах зээлийн ил тод байдлыг дээшлүүлнэ.

2.6. Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх бололцоо бүрдүүлэх, хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр банкны салбарын эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

2.7. Ипотекийн анхдагч ба хоёрдогч зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь эрчимжүүлнэ.

2.8. Монгол Улсын төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төлбөр тооцооны системийн үйл ажиллагаанд хяналт тавих, найдвартай, шуурхай байдлыг хангахад шаардлагатай дэвшилтэт технологийг нэвтрүүлэх болон бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.9. Төв банк, банкны салбарт мэдээллийн технологийн аудит, хяналт, шалгалтыг иж бүрнээр нь хэрэгжүүлж эхлэх, Төлбөр тооцооны төв, Төрийн сан, банкууд бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөөц төлөвлөгөө, нөөц төвтэй байх шаардлагыг ханган ажиллуулахад тавих хяналтыг сайжруулна.

2.10. Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хадгаламжийн даатгалын болон банкны хяналт, шалгалтын нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.11. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор урт хугацаатай зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

2.12. Банкны салбарын шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, сумдад банкны үйлчилгээний өрсөлдөөнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.13. Гадаад зах зээлээс урт хугацаатай, бага хүүтэй эх үүсвэрийг арилжааны банкуудад байршуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Төв банкны үйл ажиллагааны хүрээнд

3.1. Монголбанкны үйл ажиллагааны бие даасан, ил тод байдлыг бэхжүүлж, олон нийтийн дунд инфляцийн буруу хүлээлт үүсэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллана.

3.2. Банкны салбарын ил тод, найдвартай байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагч нарын итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

3.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг идэвхжүүлэн энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллага, бусад улсын ижил төрлийн албадтай хамтарч ажиллана.

3.4. Монголбанкнаас олон нийт, зах зээлтэй харилцах харилцааг улам эрчимжүүлж, Төв банкны үйл ажиллагааны талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэн явуулна.

3.5. Банкны мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг шуурхай дамжуулах нөхцлийг бүрдүүлнэ.

3.6. Улсын Их Хурлаас Төв банкинд тавих хяналтыг тогтмолжуулж, Монголбанкны Хяналтын зөвлөлийн бие даасан байдал, эрх зүйн орчныг сайжруулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 96 дугаар тогтоолын 1 дэх заалтын "7 дугаар сарын

1-ний өдөр" гэснийг "11 дүгээр сарын 01-ний өдөр" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Хууль, тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн зарим хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн хууль санаачлагч нь өөрчлөгдсөн, зарим

төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын санал авах шаардлагатай байгаа зэргийг харгалзан хавсралтад дурдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 39 дүгээр тогтоолын хавсралт

ХУУЛЬ САНААЧЛАГЧИД НЬ БУЦААХ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2. Хязгаарлагдмал казиногийн тухай, Хязгаарлагдмал казиногийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

7. "Нийгмийн хөгжилд хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог дэмжих талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

8. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9. Орон гэргүй иргэдийг дэмжих тухай хуулийн төсөл;

3. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

4. Бэлчээрийн тухай хуулийн төсөл;

5. "Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн дүн мэдээг хянан нягтлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

11. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүд;

6. "Монгол Улсын иргэнд эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр

12. "Улаанбаатар хотын утааг арилгахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2008 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 345

 Улаанбаатар
хот

Шадравын Түдэвт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Сургалт-эрдэм шинжилгээ, төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж эрдэм судлалын бүтээлүүд туурвин, Удирдлагын академийн сургалт үйлдвэрлэлийн зохион байгуулалт, сургалтын агуулга төлөвлөгөө, хөтөлбөрт үндсэн өөрчлөлт, шинэчлэлт хийж, монголын нийгмийн менежментийн чадавхийг

бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн дэд захирал Шадравын Түдэвт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2008 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 346

 Улаанбаатар
хот

Лувсансүрэнгийн Дамдинсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Төр захиргааны төв болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж Хүнсний аж үйлдвэрийн салбарт шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, үндэсний хүнсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг

нь үнэлж Монголын хүнсчдийн холбооны гүйцэтгэх захирал Лувсансүрэнгийн Дамдинсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2008 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 347

 Улаанбаатар
хот

Чулуундоржийн Янжмаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монгол телевизэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, хүүхэд багачуудын сонирхолд нийцсэн олон арван нэвтрүүлэг болон хөрөг найруулал, баримтат киног мэргэжлийн өндөр түвшинд найруулан бүтээж, телевизийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, Монгол телевизийг хөгжүүлэхэд

орруулсан хувь нэмрийг нь үнэлж Радио телевизийн дээд сургуулийн найруулагч, багш Чулуундоржийн Янжмаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1